



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянзүрх дүүргийн “Тэгшдүүрэн хүслэн” ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/016/НА-СТА-ОНӨҮГ

| | |
|---|--|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p> | <p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 11315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 11315558 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: СМД аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал: Д.Гэндэнпэлжээ Утас: 99110699 Цахим хаяг: munkhtsatsral@cmdaudit.mn Аудитор: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyam1202@gmail.com</p> |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

| | |
|---|----|
| ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ | 1 |
| НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 2 |
| ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ..... | 4 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан..... | 4 |
| 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан | 4 |
| 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 5 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 5 |
| 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 6 |
| 3.1 Залруулсан алдаа | 6 |
| 3.2 Албан шаардлага | 6 |
| 3.3 Зөвлөмж..... | 7 |
| ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ..... | 9 |
| 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл | 9 |
| 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл | 9 |
| 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 10 |
| Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл | 10 |

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|--------|--|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МӨАУМХ | Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| НТАГ | Нийслэл дэх Төрийн аудитын газар |
| НӨХГ | Нийслэлийн өмчийн харилцааны газар |
| ӨЭМТ | Өрхийн эрүүл мэндийн төв |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ЭМДС | Эрүүл мэндийн даатгалын сан |
| ЭМДЕГ | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар |
| ЭМДҮЗ | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл |
| ЭМС | Эрүүл мэндийн сайд |

НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-03-13 № 500
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ
ДҮҮРГИЙН ТЭГШДҮҮРЭН ХҮСЛЭН
ӨЭМТ-ИЙН ДАРГА Ё.СУГАРБАЯР
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Баянзүрх дүүргийн Тэгшдүүрэн хүслэн ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Тэгшдүүрэн хүслэн ӨЭМТ нь Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд ногдох зардлын санхүүжилтээр 1,200.5 сая төгрөгийн, 4 төрлийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтээр 306.5 сая төгрөгийн, нийт 1,507.0 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, эрүүл мэндийн ерөнхий газрын санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 46 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/47 дугаар захирамжаар 100.8

1426050519

C:\Users\inangua\Desktop\Бичир хэргийг гүйцэтгэх үйлчилгээний байршил Дүгнэлт-2026.docx

хувь, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах даатгалын гэрээний биелэлтийг 96.3 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|-----------------------|-----------------------|
| 1. ХӨРӨНГӨ | - | - |
| 1.1 Эргэлтийн хөрөнгө | - | - |
| 1.1.1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 101,447,317.73 | 184,242,074.98 |
| 1.1.2 Дансны авлага | 93,869,036.99 | 36,588,273.97 |
| 1.1.6 Бараа материал | 157,290,126.26 | 211,133,830.42 |
| 1.1.11 Эргэлтийн хөрөнгийн дүн | 352,606,480.98 | 431,964,179.37 |
| 1.2 Эргэлтийн бус хөрөнгө | - | - |
| 1.2.1 Үндсэн хөрөнгө | 145,523,970.19 | 103,787,783.71 |
| 1.2.10 Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 145,523,970.19 | 103,787,783.71 |
| 1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 498,130,451.17 | 535,751,963.08 |
| 2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | - | - |
| 2.1 Өр төлбөр | - | - |
| 2.1.1 Богино хугацаат өр төлбөр | - | - |
| 2.1.1.1 Дансны өглөг | 954,816.60 | - |
| 2.1.1.4 НДШ - ийн өглөг | 2,281,181.24 | - |
| 2.1.1.8 Урьдчилж орсон орлого | 120,211,069.00 | - |
| 2.1.1.10 Бусад богино хугацаат өр төлбөр | 5,048,076.99 | - |
| 2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн | 128,495,143.83 | - |
| 2.2 Өр төлбөрийн нийт дүн | 128,495,143.83 | - |
| 2.3 Эздийн өмч | - | - |
| 2.3.1 Өмч: | 45,149,647.89 | 45,149,647.89 |
| 2.3.1.1 - төрийн | 45,149,647.89 | 45,149,647.89 |
| 2.3.7 Хуримтлагдсан ашиг | 324,485,659.45 | 490,602,315.19 |
| 2.3.9 Эздийн өмчийн дүн | 369,635,307.34 | 535,751,963.08 |
| 2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 498,130,451.17 | 535,751,963.08 |

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|------------------------|-----------------------|
| 1. Борлуулалтын орлого (цэвэр) | - | - |
| 2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | - | - |
| 3. Нийт ашиг (алдагдал) | - | - |
| 4. Санхүүжилтийн орлого | 1,182,649,718.24 | 1,507,042,516.60 |
| 5. Хүүгийн орлого | 1,470,758.90 | 1,777,207.62 |
| 6. Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 24,148,425.40 | 123,461,069.00 |
| 8. Бусад орлого | 32,394,340.00 | 12,734,725.60 |
| 9. Борлуулалт, маркетингийн зардал | - | - |
| 10. Ерөнхий ба удирдлагын зардал | 1,313,386,164.94 | 1,478,898,864.08 |
| 11. Санхүүгийн зардал | - | - |
| 18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | (72,722,922.40) | 166,116,654.74 |
| 19. Орлогын татварын зардал | - | - |
| 20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | (72,722,922.40) | 166,116,654.74 |
| 22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | (72,722,922.40) | 166,116,654.74 |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмч | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|----------------------|-----------------------|-----------------------|
| 2. Залруулсан үлдэгдэл | 45,149,647.89 | 397,208,581.85 | 442,358,229.74 |
| 3. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | (72,722,922.40) | (72,722,922.40) |
| 8. Эхний үлдэгдэл | 45,149,647.89 | 324,485,659.45 | 369,635,307.34 |
| 9. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | | |
| 10. Залруулсан үлдэгдэл | 45,149,647.89 | 324,485,660.45 | 369,635,308.34 |
| 11. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | 166,116,654.74 | 166,116,654.74 |
| 16. Эцсийн үлдэгдэл | 45,149,647.89 | 490,602,315.19 | 535,751,963.08 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--|-------------------------|-------------------------|
| 1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | - | - |
| 1.1 Мөнгөн орлогын дүн | 1,170,758,978.86 | 1,502,811,974.62 |
| 1.1.1 Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 1,170,758,978.86 | 321,022,933.22 |
| 1.1.5 Татаас, санхүүжилтийн орлого | - | 1,181,789,041.40 |
| 1.1.6 Бусад мөнгөн орлого | - | - |
| 1.2 Мөнгөн зарлагын дүн | 1,259,440,215.37 | 1,398,857,217.37 |
| 1.2.1 Ажиллагчдад төлсөн | 918,696,663.52 | 964,581,305.88 |
| 1.2.2 Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | - | 118,887,954.62 |
| 1.2.3 Бараа материал худалдан авахад төлсөн | 26,709,300.00 | 182,648,262.00 |
| 1.2.4 Ашиглалтын зардалд төлсөн | 33,300,000.00 | - |
| 1.2.5 Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 351,853.11 | 2,057,114.00 |
| 1.2.7 Татварын байгууллагад төлсөн | 88,546,253.92 | - |
| 1.2.9 Бусад мөнгөн зарлага | 191,836,144.82 | 130,682,580.87 |
| 1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (88,681,236.51) | 103,954,757.25 |
| 2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | - | - |
| 2.1 Мөнгөн орлогын дүн | - | - |
| 2.2 Мөнгөн зарлагын дүн | 28,019,000.00 | 21,160,000.00 |
| 2.2.1 Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 28,019,000.00 | 21,160,000.00 |
| 2.3 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (28,019,000.00) | (21,160,000.00) |
| 3.4 Валютын ханшийн зөрүү | 156,132.14 | - |
| 4. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | (116,544,104.37) | 82,794,757.25 |
| 5. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 217,991,422.10 | 101,447,317.73 |
| 6. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 101,447,317.73 | 184,242,074.98 |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 89,367.7 мянган төгрөгийн 4 зөрчил¹ илэрснээс 10,480.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага өгч, 78,887.7 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 2 зөвлөмж өгч, нийцлийн аудиттай холбоотой 101,120.5 мянган төгрөгийн 2 зөрчил илэрч 101,120.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 89,367.7 мянган төгрөгийн алдаа, зөрчлөөс санхүүгийн тайлагналтай холбоотой 11,824.7 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 9,569.7 мянган төгрөгийн 1 алдаа² илэрснийг аудитын явцад залруулга хийлгэж, баталгаажуулсан. Үүнд:

- Нийгмийн даатгалын хэлтэст илүү төлсөн 9,569.7 мянган төгрөгийн шимтгэлийн авлагыг нягтлан бодогч шимтгэлийн өглөгийн данснаас авлагаар тохируулах бичилт хийхдээ өмч хувьчлалын орлого гэсэн данс сонгосноос санхүүгийн үр дүнгийн тайланд орлогоор тусган тайлан буруу илэрхийлэгдсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 “Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх” заалттай зөрчилдөж байгаа бөгөөд санхүүгийн тайлагналын “үнэлгээ ба хуваарилалт”, “ангилал”, “иж бүрэн байх”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

3.2 Албан шаардлага

1. Байгууллагаас ажлын байрны стресс тайлах сургалт аяллыг зохион байгуулах арга хэмжээнд 4,480.0 мянган төгрөгийг зарцуулахдаа тушаал шийдвэр гаргаагүй, Нөхөрлөлийн хурлын тэмдэглэлийг үндэслэн шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан 4,480.0 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоож, төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

2. Цалингийн урьдчилгаа 6,000,0 мянган төгрөгийг авлагаар тусгаагүй, авлагыг тайлант онд барагдуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т " Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага заавал бүртгэнэ" гэсэн заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын"Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урьдчилгаа цалингийн 6,000.0 мянган төгрөгийг суутган тооцож авлагыг барагдуулан цаашид зөрчлийг таслан зогсоож,авлагыг ондоо бүрэн барагдуулж байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3. Тайлант онд эм, эмнэлгийн хэрэгслийн 101,120.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авахдаа худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.1-д " Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно" гэсэн заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын"Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материал худалдан авахдаа худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой асуудал:

Илрүүлэлт-1. Тайлант онд 1,344.7 мянган төгрөгийн шатахууны үнийг бэлтгэн нийлүүлэгч байгууллагад төлж, тайланд харилцах байгууллагаар тооцоо үүсгэн, бараа материалын тайланд орлого аваагүй, жолоочийн замын хуудсаар зарцуулалтыг гарган шууд зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог" дахь заалтыг нягтлан бодогч хэрэгжүүлээгүй, хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" заалтад заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "Толилуулга", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шатахууны орлого зарцуулалтыг бараа материалын тайланд бүрэн тусган, зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж ажиллах зөвлөмж өгөв.

Илрүүлэлт-2. Тус байгууллагын эд хариуцагч сараар нэгтгэн эмийн тайланг нягтлан бодогчид хянуулаагүй, санхүүгийн программд зарлагыг тусгаагүй 10 сард 77,543.0 мянган төгрөгийн зарлагын тайланг гаргасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага заавал бүртгэнэ", гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “*Толилуулга*”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эм, эмнэлгийн хэрэгслийн тайланг сар бүр гарган, санхүүгийн тайланг зөв илэрхийлж, үлдэгдлийг санхүүгийн программ дахь үлдэгдэлтэй тулган баталгаажуулж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулан ажиллах зөвлөмж өгөв.

Илрүүлэлт-3. Шилэн дансны цахим хуудсанд улирал бүр мэдээлэх нийт 1,579,264.7 мянган төгрөгийн орлогын 4 мэдээллээс 1 улирлын мэдээллийг хугацаа хоцроосон, үнийн дүнг өссөн дүнгээр 93,902.6 мянган төгрөгийг дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д “Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, **Засгийн газрын** болон орон нутгийн тусгай зориулалтын сан, ОНХС-ийн хөрөнгө оруулалт, **санхүүжилт**, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, **хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг** Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй” заалтад заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “*Толилуулга*”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим сайтад Эрүүл мэндийн даатгалын сангаас авсан санхүүжилтийн орлого, зарцуулалтын мэдээллийг үнэн зөв, хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмж өгсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг НТАГ-т 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|------------|----------------|-----------------------------------|-----|--------------------------|----------------|------------|----------------|---------------|-----|---------|-----|
| | | | | | | | Залруулсан | | Залруул аагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүү үр дүнгийн тайланд НДШ-ийн авлагын 9,569.7 мянган төгрөгийн авлага үүсгэсэн бичилтийг хийхдээ өмч хувьчлалын орлого дансанд бүртгэж тайлагнасан. | 1 | 9,569.7 | | | 1 | 9,569.7 | 1 | 9,569.7 | | | | |
| Дүн | 1 | 9,569.7 | | | 1 | 9,569.7 | 1 | 9,569.7 | | | | |

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|-------------|---------|---------------|-----|-----------------|---------|---------|---------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант онд 1,344.7 мянган төгрөгийн шатахууны үнийг бэлтгэн нийлүүлэгч байгууллагад төлж, тайланд харилцах байгууллагаар тооцоо үүсгэн, бараа материалын тайланд орлого аваагүй, жолоочийн замын хуудсаар зарцуулалтыг гарган шууд зардлаар бүртгэсэн байна. | 1 | 1,344.7 | | | | | 1 | 1,344.7 |
| Байгууллагаас ажлын байрны стресс тайлах сургалт аяллыг зохион байгуулах арга хэмжээнд 4,480.0 мянган төгрөгийг зарцуулахдаа тушаал шийдвэр гаргаагүй, Нөхөрлөлийн хурлын тэмдэглэлийг үндэслэн шилжүүлсэн байна. | 1 | 4,480.0 | | | 1 | 4,480.0 | | |
| Цалингийн урьдчилгаа 6,000,0 мянган төгрөгийг авлагаар тусгаагүй, авлагыг тайлант онд барагдуулаагүй. | 1 | 6,000.0 | | | 1 | 6,000.0 | | |

Нийслэлийн Баянзүрх дүүргийн “Тэгшдүүрэн хүслэн” ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | | | | | | | |
|---|----------|-----------------|---|---|----------|-----------------|----------|-----------------|
| Тус байгууллагын эд хариуцагч сараар нэгтгэн эмийн тайланг нягтлан бодогчид хянуулаагүй, санхүүгийн программд зарлагыг тусгаагүй 10 сард 77,543.0 мянган төгрөгийн зарлагын тайланг гаргасан. | 1 | 77,543.0 | | | | | 1 | 77,543.0 |
| Дүн | 4 | 89,367.7 | - | - | 2 | 10,480.0 | 2 | 78,887.7 |

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|------------------|---------------|-----|-----------------|------------------|----------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант онд эм, эмнэлгийн хэрэгслийн 101,120.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авахдаа худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн. | 1 | 101,120.5 | | | 1 | 101,120.5 | | |
| Шилэн дансны цахим хуудсанд улирал бүр мэдээлэх нийт 1,579,264.7 мянган төгрөгийн орлогын 4 мэдээллээс 1 улирлын мэдээллийг хугацаа хоцроосон, үнийн дүнг өссөн дүнгээр 93,902.6 мянган төгрөгийг дутуу мэдээлсэн байна. | 1 | - | | | | | 1 | - |
| Дүн | 2 | 101,120.5 | - | - | 1 | 101,120.5 | 1 | - |

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

| Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | | |
|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|---------------------------|---|
| | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | Зөрчлөгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өөхөөс талгаалсан | |
| | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | | | | | |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | ОНӨҮГ | | 1 | | | 1 | | | |
| | НИЙТ | | 1 | | | 1 | | | |



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 204/Б1770255

Улаанбаатар хот

НТАГ-2026/016/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Тэгш дүүрэн хүслэн Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн урьдчилгаа 6,000,000.0 (зургаан сая) төгрөгийг тайлант онд суутган тооцоогүй, авлагаар тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Урьдчилгаа цалингийн авлага 6,000,000.0 (зургаан сая) төгрөгийг бүртгэлд тусгаагүй, барагдуулаагүй зөрчлийг зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тэгш дүүрэн хүслэн Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Ё.Сугарбаяр, нягтлан бодогч Ж.Мөнхтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"СМД АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
А.ЦЭЭНЯМ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090463



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 295 / Б.1970235

Улаанбаатар хот

НТАГ-2026/016/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Тэгш дүүрэн хүслэн Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагаас ажлын байрны стресс тайлах сургалт аяллыг зохион байгуулах арга хэмжээнд 4,480,000.0 (дөрвөн сая дөрвөн зуун наян мянга) төгрөгийг зарцуулахдаа тушаал шийдвэр гаргаагүй, Нөхөрлөлийн хурлын тэмдэглэлийг үндэслэн шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалтад заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар сургалтын зардалд зарцуулсан 4,480,000.0 (дөрвөн сая дөрвөн зуун наян мянга) төгрөгийн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тэгш дүүрэн хүслэн Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Ё.Сугарбаяр, нягтлан бодогч Ж.Мөнхтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"СМД АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
А.ЦЭЭНЯМ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426090465



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 206/Б1990235

Улаанбаатар хот

НТАГ-2026/016/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Тэгш дүүрэн хүслэн Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд эм, эмнэлгийн хэрэгслийн 101,120,451.0 (нэг зуун нэг сая нэг зуун хорин мянга дөрвөн зуун тавин нэг) төгрөгийн бараа материал худалдан авахдаа худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал харууцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулаагүй зөрчлийг зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тэгш дүүрэн хүслэн ӨЭМТ-н дарга Ё.Сугарбаяр, нягтлан бодогч Ж.Мөнхтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"СМД АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
А.ЦЭЭНЯМ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426090466